# Сэдэв: Инкотермсийн CIF нөхцөл



2018 он

# БАРАА, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХҮРГЭЛТИЙН ЕРӨНХИЙ ЗУРАГЛАЛ

EXPORT DEVELOPMENT PROJECT



# CIF – COST, INSURANCE AND FREIGHT

EXPORT DEVELOPMENT PROJECT

## Очих боомт хүртэл зардал, тээвэрлэлт, даатгалыг төлсөн

1. Худалдагч нь “бараа, бүтээгдэхүүнийг талуудын тохиролцсон нэр бүхий ачих боомтод байрлах усан онгоцны тавцанд хүргэж мөн очих боомт хүртэлх зардал, тээвэрлэлт, даатгалыг төлж” хүргэх нөхцөл.
2. Худалдагч бараа, бүтээгдэхүүнийг усан онгоцны тавцанд хүргэснээр алдагдал, эвдрэл гэмтлийн эрсдэл худалдан авагч талд шилждэг.
3. Энэ нөхцөлийг зөвхөн далайн болоод дотоодын усан тээвэрт ашиглана.



# CIF НӨХЦӨЛИЙН ТЭЭВЭРЛЭЛТ, ХҮРГЭЛТ

EXPORT DEVELOPMENT PROJECT

Худалдагч нь бараа, бүтээгдэхүүнийг (1) тохиролцсон ачих боомтын усан онгоцны тавцанд хүргэж (2) очих боомт хүртэлх тээвэрлэлт, зардал, даатгалыг нь төлж хүргэнэ.




CIF нөхцөлөөр худалдагч нь “бараа, бүтээгдэхүүнийг талуудын тохиролцсон нэр бүхий ачих боомтод байрлах усан онгоцны тавцанд хүргэж мөн очих боомт хүртэлх зардал, тээвэрлэлт, даатгалыг төлж” хүргэдэг.

# CIF НӨХЦӨЛИЙН ОНЦЛОГ ТАЛУУД

EXPORT DEVELOPMENT PROJECT

- Эрсдэл, зардлууд өөр өөр газарт худалдагчаас худалдан авагч руу шилждэг.
- Ачилт хийгддэг боомт дээр бараа, бүтээгдэхүүний эрсдэл худалдагчаас худалдан авагч руу шилждэг. Тиймээс талууд бараа, бүтээгдэхүүний хүргэлтийг хийх "нэр бүхий ачаалах боомт болон усан онгоцыг" нарийвчлан тохиролцох шаардлагатай.
- Худалдагч бараа, бүтээгдэхүүнийг усан онгоцны тавцанд хүргэх болон очих боомт хүртэлх тээвэрлэлтийн гэрээг хийж зардлыг нь төлнө.
- Худалдагч нь бараа, бүтээгдэхүүнийг очих боомт хүртэл тээвэрлэх үед гарах "алдагдал, эвдрэл гэмтлийн эрсдэлээс" хамгаалах хамгийн доод хэмжээний нөхөн төлбөр бүхий энгийн даатгалын гэрээ хийдэг.
- Худалдагч буулгах цэг хүртэлх зардлыг хариуцдаг. Тиймээс бараа, бүтээгдэхүүнийг буулгах цэгүүдийг нарийвчлан тохирох шаардлагатай.
- Худалдагч бараа, бүтээгдэхүүний экспортын гаалийн бүрдүүлэлт, үзлэг шалгалтыг хариуцна.
- Худалдан авагч импортын гаалийн бүрдүүлэлт, үзлэг шалгалтыг хариуцна.

# CIF НӨХЦӨЛИЙН БҮДҮҮВЧ ЗУРАГЛАЛ



# CIF НӨХЦӨЛИЙН ДАГУУ ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА, ЗАРДАЛ



| Хүлээх үүрэг хариуцлага, зардал | ХУДАЛДАГЧ | ХУДАЛДАН АВАГЧ |
|---|---|---|
| 1. Барааны баглаа, боодол, тэмдэглэгээ, шошго | ✓ | ✗ |
| 2. Экспортын гаалийн бүрдүүлэлт, үзлэг шалгалт | ✓ | ✗ |
| 3. Анхдагч тээвэрлэлт (үндсэн тээвэрлэгч рүү)-ийг гэрээлэх, төлөх | ✓ | ✗ |
| Анхдагч тээврийн хэрэгсэлд ачих | ✓ | ✗ |
| Анхдагч тээврийн хэрэгслээс буулгах | ✓ | ✗ |
| 4. Үндсэн тээвэрлэлтийг гэрээлэх, төлөх | ✓ | ✗ |
| Үндсэн тээврийн хэрэгсэлд ачих | ✓ | ✗ |
| Үндсэн тээврийн хэрэгслээс буулгах | ✗ | ✓ |
| 5. Эцсийн тээвэрлэлт (худалдан авагч)- ийг гэрээлэх, төлөх | ✗ | ✓ |
| Эцсийн тээврийн хэрэгсэлд ачих, буулгах | ✗ | ✓ |
| 6. Импортын гаалийн бүрдүүлэлт, үзлэг шалгалт | ✗ | ✓ |
| 7. Даатгал | ✓ | ✗ |

# CIF БОЛОН БУСАД НӨХЦӨЛҮҮД

EXPORT DEVELOPMENT PROJECT

Худалдагч Худалдан авагч

| Талуудын хүлээх үүрэг, төлбөр, хариуцлага, эрсдэл | Бүх төрлийн тээвэр | | | | | | | Далайн болон дотоодын усан | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | EXW | FCA | CPT | CIP | DAT | DAP | DDP | FAS | FOB | CFR | CIF |
| Зардлын харьцуулсан хэмжээ $ | $ | $$ | $$$ | $$$ | $$$$ | $$$$ | $$$$$ | $$ | $$ | $$$ | $$$ |
| Барааны баглаа боодол | | | | | | | | | | | |
| Барааны тэмдэглэгээ, шошго | | | | | | | | | | | |
| Экспортын зөвшөөрөл | | | | | | | | | | | |
| Ачаа дамжуулагчийн төлбөр | | | | | | | | | | | |
| Үндсэн тээвэрлэгч рүү хүргэх | | тохиролцоно | | | | | | | | | |
| Үндсэн терминалын хураамж | | | | | | | | | | | |
| Усан онгоцонд ачуулах хураамж | | | | | | | | | | | |
| Усан тээвэр/агаарын тээвэр | | | | | | | | | | | |
| Экспортын барааг дамжуулагчийг сонгох | | | | | | | | | | | |
| Далайн даатгал | Худалдааны гэрээгээр зохицуулна. | | | | Худалдааны гэрээгээр зохицуулна. | | | Худалдааны гэрээгээр зохицуулна. | | | |
| Үндсэн тээвэрлэгчээс ачааг буулгах хураамж | | | Тээвэрлэлтийн гэрээнээс шалтгаалж аль нэг тал төлнө. | | | | | | | Тээвэрлэлтийн гэрээнээс шалтгаалж аль нэг тал төлнө. | |
| Очих газрын терминалын хураамж | | | Тээвэрлэлтийн гэрээнээс шалтгаалж аль нэг тал төлнө | | | | | | | | |
| Тээвэрлэгчийг сонгох | | | Төлбөрийн хшигээс хамаарч аль нэг тал нь төлнө. | | | | | | | | |
| Хилээр орох шаардлагууд | | | | | | | | | | | |
| Гаалийн үзлэг шалгалтын төлбөр | | | | | | | | | | | |
| Гаалийн хураамж, Татвар | | | | | | | | | | | |
| Худалдан авагч руу хүргэх | | | Төлбөрийн хшигээс хамаарч аль нэг тал нь төлнө. | | | | | | | | |
| Ачааг буулгах | | | | | | | | | | | |

# АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА